

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.06.18-06.22

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын компаниудын хувьцааны ханш харьцангуй тогтвортой байсан ч уналттай хаагдлаа. S&P 500 индекст багтдаг өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэгч болон үл хөдлөх хөрөнгийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн байна. Засгийн газрын урт хугацаат бондын өгөөж буурснаар эдгээр компаниудын ногдол ашиг хөрөнгө оруулагчдын анхаарлыг татсан байна. АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан гүнзгийсэн явдал аж үйлдвэрлэлийн салбарын, тэр дундаа Boeing болон Caterpillar компаниудын хувьцааны ханшид сөргөөр нөлөөлжээ.

Энэ долоо хоногт АНУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар БНХАУ-ын 200 сая ам.доллартай тэнцэх хэмжээний импортын бараанд татвар ногдуулах талаар мэдээлсэнтэй холбогдуулан зах зээлийн ханш унасан байна.

Мөн Герман улсын автомашин үйлдвэрлэгч Daimler компани АНУ-д угсран, БНХАУ-д нийлүүлдэг авто машинахаа тоог багасгах талаар мэдээлжээ. Энэ нь БНХАУ автомашины импортод гаалийн татвар ногдуулах талаар мэдээлж байсантай холбоотой билээ.

Баасан гарагт ОПЕК-ийн орнууд газрын тосны үйлдвэрлэлээ маш бага хэмжээгээр нэмэхээр болсон явдал эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш өсөхөд нөлөөлжээ.

Европ: Европын компаниудын хувьцааны ханшид АНУ, Европ хоорондын худалдааны маргаан ихээр нөлөөлжээ. Европын орнууд АНУ-ын 3.2 тэрбум ам.доллартай тэнцэх бараа бүтээгдэхүүнд гаалийн татвар ногдуулсан билээ. Үүний хариуд АНУ Европоос импортлодог ган, хөнгөн цагаанд тариф ногдуулсан. Худалдааны маргаан Европын уул уурхай, авто машин үйлдвэрлэл болон мэдээлэл технологийн салбарын компаниудын хувьцааны ханшид сөргөөр нөлөөлөв.

Английн төв банк бодлогын хүүгээ өөрчлөхгүй байхаар шийдсэн нь фунтын ханшийг чангаруулсан байна. Эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш өссөнтэй холбогдуулан FTSE 100 индекс өсөлттэй хаагджээ.

Грек улс өрийнхөө асуудлыг шийдвэрлэв. Тус улсын 100 тэрбум еврогийн өрийг ахин 10 жилээр сунгасан байна.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш уналттай хаагдлаа. Иений ханш ам. долларын эсрэг 110.1 нэгж болж хаагдсан нь 2017 оны эцсээс 2.2%-аар чангарсан байна.

Японы үйлдвэрчний эвлэл цалингийн хэмжээ 2.1%-аар нэмж байгаа талаар мэдээлэв. Энэ нь тус улсын Ерөнхий сайдын амлаж байсан 3%-аас бага үзүүлэлт ажээ.

БНХАУ: БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч, худалдааны маргаан гүнзгийрч байгаатай холбогдуулан тус улсын компаниудын хувьцааны ханш унасан байна.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,542.96	-1.42% ▼
Dow Jones	АНУ	24,580.89	-2.03% ▼
S&P 500	АНУ	2,754.88	-0.89% ▼
Nasdaq	АНУ	7,692.82	-0.69% ▼
S&P/TSX	Канад	16,450.14	0.83% ▲
FTSE 100	Их Британи	7,682.27	0.63% ▲
S&P/ASX 200	Австрали	6,225.20	2.15% ▲
Nikkei 225	Япон	22,516.83	-1.47% ▼
Hang Seng	Хонг Конг	29,338.70	-3.20% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	108.27
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	95.32
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	94.51
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.07
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.06
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.60
TDBM' 2020	USD	9.3%	105.71

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.098	0.01 ▲
Libor 3M	2.339	0.01 ▲
Libor 6M	2.508	0.00 ▲
Libor 1YR	2.777	0.00 ▲
US 6M Bond	2.079	0.02 ▲
US 2YR Bond	2.529	-0.01 ▼
US 3YR Bond	2.622	-0.04 ▼
US 5YR Bond	2.743	-0.04 ▼
US 10YR Bond	2.871	-0.04 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.06.22	Өөрчлөлт
USD	2,454.05	1.46% ▲
CNY	377.68	0.16% ▲
EUR	2,859.46	2.00% ▲
RUB	38.82	0.78% ▲
KRW	2.22	0.45% ▲
JPY	22.28	1.78% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,268.17	-0.84% ▼
Мөнгө /spot/	16.37	-1.21% ▼
Эс	305.70	-2.52% ▼
Нүүрс	107.25	-3.22% ▼
WTI газрын тос	68.39	6.23% ▲
Brent газрын тос	74.22	1.06% ▲
Байгалийн хий	2.92	-3.63% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018.IV	6.00%
Бодлогын хүү	2018.IV	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.IV	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.IV	12.80%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.IV	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.IV	19.30%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.IV	10.20%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 54 компанийн 828.6 сая төгрөгийн 2,963,816 ширхэг хувьцаа арилжигдав.

“Э-Транс ложистикс” /ETR/ компанийн хувьцаа 17.86%-аар буюу хамгийн ихээр өсч 82.5 төгрөгт хүрч хаагдсан бол “Адуун чулуун” /ADL/ компанийн хувьцаа 16.98%-аар буурч 2,200 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 172 ширхэг үнэт цаас 17.4 сая төгрөгөөр арилжаалагджээ.

Компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр арилжаа явагдаагүй байна.


6-р сарын 22-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,439.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,542.96 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.42%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	2,607.4
Зах зээлийн үнэлгээ	2,439,056.1

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,542.96	-1.42% ▼
MSE I индекс	9,524.44	-0.60% ▼
MSE II индекс	9,604.13	-3.35% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
БиДиСек	1,609,903	1,610,068,990
ЛэндМН ББСБ	680,901	266,697,753
Эрдэнэ Ресурс	193,777	128,960,949
АПУ	184,058	107,036,981
Таван Толгой	8,274	82,271,870

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Э-Транс ложистикс	82.50	17.86% ▲
Хөвсгөл алтан дуулга	215.18	15.00% ▲
Люкс зананду групп	880.57	15.00% ▲
Хүрд	1,851.00	14.97% ▲
Дархан гурил тэжээл	780.00	13.97% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Адуун чулуун	2,200.00	-16.98% ▼
Хай Би Ойл	57.00	-13.56% ▼
Гутал	19,560.00	-13.07% ▼
Могойн гол	8,000.00	-13.04% ▼
Монинжбар	150.00	-11.76% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
БиДиСек	3,709,973,265
Гаули	245,610,730
Голомт капитал	194,559,468
ТиДиБи Капитал	190,949,666
Стандарт инвестмент	145,708,337

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	577.71	614,788
Таван толгой	10,020.00	527,705
МИК	10,500.00	217,448
Говь	23,820.00	185,823
Сүү	209.97	72,230

ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-04/07/19-A0266-14.82	72	7,200,000	100,000	100,000	104	14.820
2	ZGEB-BD-11/04/19-A0230-18	100	10,175,000	101,750	101,750	104	18.000

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ERS	Монгол алт ХК	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
2	TEE	Тээвэр дархан ХК	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
3	TTL	Таван Толгой ХК	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
4	EER	Ариг гал ХК	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с	Тодорхойгүй
5	BDL	Могойн гол ХК	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	Тодорхойгүй	Тодорхойгүй
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с	Тодорхойгүй
7	TAL	Талын гал ХК	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
8	BRC	Барилга корпораци ХК	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	AND	Анд-Энерги ХК	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
10	SUL	Жуулчин дюти фрий ХК	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с	Компанийн байранд
11	GTL	Гутал ХК	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с	Тодорхойгүй
12	BNG	Баянгол зочид буудал ХК	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с	Компанийн байранд
13	APU	АПУ ХК	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
14	BTG	Баянтээг ХК	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
15	MIE	Материалимпекс ХК	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
16	HRD	Хүрд ХК	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор	Тодорхойгүй
17	SUU	Сүү ХК	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
18	MNP	Монгол шуудан ХК	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
19	MMX	Махимпекс ХК	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с	Компанийн байранд
20	TCK	Талх чихэр ХК	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с	Компанийн байранд
21	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
22	ADL	Адуун чулуун ХК	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	Тодорхойгүй	ҮЦТХТ-ийн данс
23	TAN	Тахь-ко ХК	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
24	UBH	Улаанбаатар хивс ХК	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
25	GOV	Говь ХК	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов	Компанийн байранд
26	HRM	Гермес центр ХК	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ Ресурс Девелопмент”-ийн хоёрдогч зах зээлийн арилжаа 2018.06.20-нд эхэллээ

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 1/2795 тоот албан бичгээр “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, тус компанийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрөл олгосон байна.

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” нь Монголын хөрөнгийн биржийн хамгийн анхны давхар бүртгэлтэй компани бөгөөд олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад 1,247 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 6,478,146 ширхэг худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнг даруй 66 хувиар давсан үзүүлэлт болсон юм.

Мөн тус компани 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс 6 дугаар сарын 08-ны өдрийн хооронд Канад улсад хаалттай хүрээнд 10,834,580 ширхэг нэмэлт хувьцааг тус бүрийг \$0.38 канад доллараар санал болгон худалдаалж, нийт 4.12 сая канад долларын хөрөнгийг амжилттай татан төвлөрүүлсэн тухай мэдээлсэн билээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Алтайн зам” ХК-ийн үнэт цаасны арилжааг түр зогсоолоо

“Алтайн зам” ХК-ийн үнэт цаас цөөн тоогоор удаа дараа арилжаалагдаж үнэт цаасны үнэ огцом өссөн нь ҮЦЗТХууль болон бусад холбогдох журмуудыг зөрчсөн байж болзошгүй гэж үзсэн тул СЗХ-ны улсын байцаагчийн 2018 оны 6 сарын 18-ны өдрийн 38 тоот албан шаардлагаар “Алтайн зам” ХК-ийн үнэт цаасны арилжааг зөрчлийн хэрэг бүртгэлийн хугацаа дуусах хүртэлх хугацаагаар түр зогсоолоо.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

МХБ: 2017 оны цэвэр ашгаас 26 компани 146 тэрбум төгрөгийн ногдол ашиг зарласан

Монголын Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй компаниуд 2017 оны ногдол ашгаа тараагаад байна. Эдгээрээс хамгийн их хэмжээний буюу 126.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг зарлаад байгаа “Тавантолгой” компани энэ сард 1500 орчим хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд нийт 1.2 орчим тэрбум төгрөгийг байршууллаа. “Тавантолгой” компани 2017 оны цэвэр ашгийн 90 хувийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэжээ. Тавдугаар сарын байдлаар тус компанийн нийт хувьцааны 87.7 хувийг гурван том хувьцаа эзэмшигч, 12.3 хувийг 1837 жижиг хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Мөн 20 орчим жил ногдол ашгаа тарааж байгаа АПУ компани тавдугаар сард 2017 оны ногдол ашгаа тараасан талаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв мэдээллээ. АПУ компанийн 6.3 хувийг олон нийт буюу жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг бөгөөд тус компани 2008 онд 100, 2016 онд хувьцаагаа 10 дахин хувааж байжээ.

2015, 2016 онд 27 компани ногдол ашгаа тарааж байсан бол 2017 оны ашгаас 26 компани ногдол ашгаа зарласан байна. Эдгээр 26 компани 2017 оны цэвэр ашгаас нийт 146 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ олгожээ.

Сүүлийн нэг жилийн хугацаанд IPO гаргасан компаниудаас “Айтүүлс” компани 2018 оны ашгаас ногдол ашгаа тараана гэдгээ мэдээлээд байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Эрдэнэс Тавантолгой”-ийн 30 хүртэлх хувийг биржээр арилжаална

Засгийн газрын ээлжит хуралдаанаар “Тавантолгой” төслийг эдийн засгийн эргэлтэд оруулах төслийг яаралтай дэгээр хэлэлцүүлэхээр УИХ-д өргөн мэдүүлэхээр болсон байна. Үүнээс өмнө тавдугаар сард УИХ дахь МАН-ын бүлэг дэмжиж, зургаадугаар сарын 14-нд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл мөн дэмжиж байгаагаа илэрхийлжээ. Тиймээс ирэх 14 хоногт багтаан УИХ-аар хэлэлцүүлэн дэмжигдвэл 180 хоногт багтаан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 30 хувьд IPO хийх бэлтгэл ажлаа хангахаар төлөвлөж байгаа талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар мэдээллээ. Дотоод, гадаадын Хөрөнгийн биржид давхар IPO хийх нь оновчтой гэж үзэж байгаа юм байна. Мөн олон улсын биржүүдээс тухайлбал, Хонгконг, Токио, Нью-Йорк, Лондон, Торонтогийн Хөрөнгийн биржүүд тодорхой саналууд ирүүлсэн гэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд мэдээллээ.

Одоогоор “Эрдэнэс Монгол”, “Эрдэнэс Тавантолгой” ХК, Засгийн газрын төлөөлөл багтсан 40 орчим хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Тавантолгойн ордын ТЭЗҮ-ийг шинэчлэх, нөөцийн нэгдсэн тайланг шинэчлэх, баяжуулах үйлдвэр, усан хангамж, авто зам, төмөр зам зэрэг дагалдах төслүүдийг бэлтгэж байгаа юм байна. 2010 онд хийсэн үнэлгээгээр Тавантолгойн бүлэг ордыг 5.7 тэрбум ам.доллараар үнэлж байсан юм. Нийт ордын нөөцийг 7.4 тэрбум тонн нүүрс гэж үзсэн бөгөөд үүнээс 5.1 тэрбум тонн нь коксжих нүүрс гэсэн үнэлгээ гарсан байна. Тиймээс долоон жилийн өмнөх үнэлгээг шинэчилнэ гэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд мөн дурдлаа.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Анд энерги” ХК жил бүр цэвэр ашгийн 5-8 хувийг ногдол ашиг болгон тараана

Монголын Үнэт цаасны биржид бүртгэлтэй, LED гэрэл үйлдвэрлэгч “Анд энерги” компанийн хувьцааны арилжаа зургаадугаар сар гарснаас хойш 9.7 сая төгрөгт хүрээд байна. Тус компанийн хувьцааны ханш IPO хийснээс хойш 30 гаруй хувиар унаж, 40 төгрөг болоод байгаа аж. “Анд энерги” компани өнгөрсөн долоо хоногт шинэ үйлдвэрийн барилгын ажлаа эхлүүлжээ. Хоёр сарын хугацаанд үргэлжилж, энэ оны наймдугаар сард барилгын ажлаа дуусгах төлөвлөгөөтэй байгаа талаараа мэдээлсэн юм. “Анд энерги” компани 2017 оны 11 дүгээр сард IPO гаргаж, олон нийтээс 1.56 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна. Төлөвлөгөөнд дурдсанчлан тус компани энэ оны дөрөвдүгээр сард тоног, төхөөрөмж худалдан авах гэрээгээ байгуулсан байна. Ингэснээр цаашид олон улсын стандартад нийцүүлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр 2018-2021 онд дотоодын гэрлийн зах зээлийн таван хувийг хангах зорилго тавин ажиллаж байгааг тус компани онцолж байгаа юм.

Үүнээс гадна “Анд энерги” компани нийт 14 нэр төрлийн 1,060 бүтээгдэхүүнийг Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц Төрийн өмчит компанид нийлүүлсэн байна. Тус компани 2017 онд 944.3 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 121.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Борлуулалтын орлогын 60.2 хувийг LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэлийн орлого эзэлж байгааг тайландаа тусгасан байна. Үлдсэн 39.8 хувийг цахилгаан тоног, төхөөрөмжийн угсралт, засвар үйлчилгээ, үйлдвэрлэлийн автоматжуулалтын ажлын орлого бүрдүүлжээ.

Цаашид “Анд энерги” компани жил бүрийн цэвэр ашгийн 5-8 хувийг ногдол ашигт хуваарилахаар болсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Aspire Mining: “Нүүрстэй” төслийн нүүрс сайн чанарынх болохыг тогтоосон

“Нүүрстэй” төслийн коксжих нүүрсний дээжид хийсэн шинжилгээгээр сайн чанарын нүүрс болохыг нь тогтоосон талаар “Aspire Mining” компани мэдээллээ.

“Нүүрстэй” төслийн коксжих нүүрсийг Япон, БНСУ-ын ган үйлдвэрлэгчдээс гадна өндөр чанарын нүүрс хэрэглэдэг БНХАУ-ын ган хайлуулах үйлдвэрүүд худалдан авах боломжтой гэдгийг энэхүү шинжилгээний дүн харууллаа” гэж “Aspire Mining” компанийн тэргүүн Дэвид Паул мэдэгдлээ. Мөн тэрбээр “Монгол Улс дэлхийн гангийн салбарт өндөр чанартай коксжих нүүрс нийлүүлэх боломжтой гэдгийг нотоллоо” гэж онцолсон байна.

Энэхүү мэдээлэлтэй зэрэгцээд тус компанийн хувьцааны ханш Австралийн Хөрөнгийн биржид 4.35 хувиар өслөө. “Нүүрстэй” төсөл нь Хөвсгөл аймагт байрладаг, Эрдэнэтийн төмөр замтай холбогдсон юм. Хамгийн сүүлд хийсэн өрөмдлөгийн дүнд жорк стандартаар 4.7 сая тонн таамаг, 8.1 сая тонн боломжит нүүрсний нөөцтэй болохыг “Aspire Mining” компани мэдээллээ. Үүнээс гадна Овоотын коксжих нүүрсний төслийн 90 хувийг эзэмшиж байгаа тус компани Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр зорьж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Xanadu Mines” хаалттай хүрээнд хувьцаа гарган, 10 сая австрали доллар татан төвлөрүүлжээ

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Xanadu Mines” компани нэгж бүрийг нь 0.17 австрали доллараар үнэлж, хаалттай хүрээнд хувьцаа гарган 10 сая австрали доллар татан төвлөрүүлсэн байна. Монгол дахь “Хармагтай” төслийн хайгуулын дүн сайн гарч байгаа нь одоо байгаа болон шинэ хөрөнгө оруулагчдыг татахад гол дэмжлэг болж байгаа гэж “Xanadu Mines” компаниас мэдэгдлээ. Тус компани алт, зэсийн “Хармагтай” төслийнхөө ил уурхайн эдийн засгийн урьдчилсан нөхцөл, зорилтот нөөц зэргийг тогтоох зэрэгт шаардлагатай хангалттай санхүүжилттэй болсон байна.

Энэхүү мэдээллийн дараа Австралийн Хөрөнгийн биржид “Xanadu Mines”-ийн хувьцааны ханш 2.7 хувиар өсөж, 0.19 австрали доллар боллоо.

Эх сурвалж: BloombergTv.mn

ЗГ: Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэл шууд нүүрс тээвэрлэх чиглэл нэмж гаргана

Засгийн газрын лхагва гарагийн хуралдаанаар Тавантолгой-Цагаан хад-Гашуунсухайт гэсэн маршрутаас гадна Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэл шууд нүүрс тээвэрлэх нэг чиглэлийг нэмж гаргахаар боллоо.

Ингэснээр өнгөрсөн гуравдугаар сараас эхлэн хил орчимд үүссэн дараалал буурна гэж тооцож байгаа юм байна. Одоогоор Тавантолгой-Цагаан хад чиглэлийн замд нүүрс тээвэрлэж байгаа автомашины цувааны урт 39 км болжээ. Харин Цагаан хад-Гашуунсухайт боомт хүртэлх замд 23 км урт цуваа үүссэн гэдгийг Засгийн газар мэдээллээ. Мөн Тавантолгойн нүүрсний ордод үйл ажиллагаа явуулдаг гурван аж ахуйн нэгжээс Цагаан хадны гаалийн баталгаат агуулах хүртэл тээвэр хийж байгаа автомашины цуваа 39 км болж сунажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Э.Энхбат: Алт олборлогч компаниудад санхүүжилтийн асуудал гол бэрхшээл хэвээр байна

Монголбанк 2018 он гарснаас хойш нийт 6.3 тонн алт худалдан авсан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэ нь 10 орчим хувиар өндөр дүн болжээ.

Оны эцэс гэхэд 22 тонн алт худалдан авахаар төлөвлөж байгаа аж. Цаашид иргэд, аж ахуйн нэгжүүдийн алт тушаалтыг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор алтны сорьцын лабораторийг Баянхонгор, Дархан-Уул аймагт байгуулахаар зорьж байна. Үйл ажиллагааг нь 9-10 дугаар сард эхлүүлэхээр төлөвлөж байгаа ажээ.

Төв банк алт тушаалт, олборлолтыг нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа нь сайшаалтай гэдгийг Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн онцоллоо. Хэдий тийм боловч алтны компаниудын дунд санхүүжилтийн асуудал гол бэрхшээл хэвээр байна гэж тэрбээр үзжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Өсөх зоос ХХК: Тонн нүүрсийг эцсийн хэрэглэгчдэд 680 юаниар борлуулж байна

Нүүрсний ханш эргэн сэргэж байгааг экспортлогч компаниуд онцолж байна. Нарийн сухайтын бүлэг ордод олборлолт хийж байгаа “Өсөх зоос” ХХК нэг тонн нүүрсийг эцсийн хэрэглэгчдэд 680 юаниар борлуулж байгаа талаараа мэдээллээ.

Ханшийн хувьд нэг хэсэг буурах хөдөлгөөн харагдаж байсан ч эргэн сэргэсэн гэдгийг тус компанийн Гүйцэтгэх захирал Чинбат онцоллоо. “SouthGobi Sands” ХХК-ийн хувьд нүүрсээ баяжуулан экспортлохоор төлөвлөж байна. Ингэснээр 2018 онд 800 мянган тонн баяжуулсан нүүрс экспортлохоор төлөвлөж байгаа аж.

Ингэхдээ тонн тутмыг нь 500-600 юаниар борлуулах зорилттой байгаа юм байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөлөгчид тавдугаар сард “Chalco” компанийн талтай уулзаж, нүүрсний үнээ 70 центээр нэмэгдүүлжээ. Одоо “Chalco”-д Зүүн Цанхийн нүүрсийг тонн тутмыг нь уурхайн амны нөхцөлөөр 60 ам.доллараар нийлүүлж байгаа аж. Нүүрсний ханш энэ онд тогтвортой байх төлөвтэй байгаа ч ирэх онд буурч магадгүй гэж Монголбанк таамаглаж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

BNEF: Ирэх 30 жилд эрчим хүчний зах зээлд нүүрсний хэрэглээ огцом буурна

Дэлхийн хөгжиж буй 70 орчим улсын эрчим хүчний салбарын өсөлтийн тайланг “Bloomberg New Energy Finance”-аас танилцууллаа. Энэхүү тайланд дэлхийн эрчим хүчний зах зээлд 2050 он гэхэд сэргээгдэх эрчим хүч зонхилох төлөвтэй байгааг онцолсон байна. Улс орнуудын Засгийн газар нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах, нар салхины эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд анхаарч байгаа нь үүнд гол түлхэц болохоор байгаа аж. Үүнээс гадна 2050 он хүртэл эрчим хүчний салбарт 11.5 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх тооцоо гарсан байна. Үүнээс 85 хувь буюу дийлэнх нь нар, салхи болон бусад байгальд ээлтэй технологийн хөрөнгө оруулалт байгаа юм. Нөгөө талаас ирэх 30 жилд эрчим хүчний зах зээл дэх нүүрсний хэрэглээ огцом буурахаар байгааг салбарын шинжээчид онцолжээ. Түүнчлэн цахилгаан автомашины эрэлт нэмэгдэхтэй зэрэгцээд цэнэг хураагуурын салбар 2050 он гэхэд 548 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татах тооцоо гарсан байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ



Борлуулалтын менежерүүдийн индекс VI сард 63.3 нэгж болж, өмнөх сараас 0.1 нэгжээр буурав

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлох зорилготой борлуулалтын менежерүүдийн индекс зургаадугаар сард 63.3 нэгж болж өмнөх сараас үл ялиг буурсан талаар “World Economics” байгууллага мэдээллээ. Энэхүү индекс өмнөх сараас 0.1 нэгжээр буурсан ч 2013 оны зургаадугаар сараас хойших дээд түвшинд хэлбэлзсэн хэвээр байна. Энэ оны дөрөвдүгээр сараас хойш голлох индексээс гадна тооцож гаргадаг таван дэд үзүүлэлт бүгд 50 нэгжээс дээш буюу өсөлтийн бүсэд оржээ. Тухайлбал, Монгол Улсын борлуулалтын өсөлтийн индекс зургаадугаар сард 66.4 нэгж болж сүүлийн таван жилийн дээд түвшинд хүрээд байна. Мөн он гарснаас хойш бизнесийн итгэлийн индекс өсөлтийн бүсэд хадгалагдаж байгаа ч бараа, үйлчилгээний үнэ тавдугаар сард огцом өссөнөөр энэхүү индекс өмнөх сараас буурчээ. Бараа, үйлчилгээний үнэ өсөхөд төгрөгийн ханш суларсан нь гол нөлөөг үзүүлсэн гэж “World Economics” тайлбарлаж байна.

Ам.долларын эсрэг төгрөгийн ханш сүүлийн хоёр сарын хугацаанд 1.3 хувиар унаад байгаа боловч Монгол Улсын хувьд бизнесийн итгэлийн индекс өндөр түвшинд хадгалагдсан хэвээр байгааг “World Economics” байгууллага тайландаа онцолжээ.

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр инфляци тавдугаар сарын байдлаар 6.1 хувьтай гарсан юм. Энэ нь өмнөх саруудтай харьцуулахад буурсан үзүүлэлт боловч дөрөвдүгээр сартай харьцуулахад 0.1 пунктээр өссөн дүн болж байна. Монголбанкны үзэж байгаагаар инфляци энэ онд зорилтот түвшин болох найм орчим хувьд тогтворжих төлөвтэй байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Уул уурхайн салбар идэвхжиж, хүнд даацын автомашины импорт огцом өслөө

2018 он гарсаар автомашины импорт өссөн дүнтэй гарлаа. Ялангуяа ачааны автомашины импорт өмнөх оны мөн үеэс 90 хувиар өсөж, 7415 болсон байна.

Ингэснээр мөнгөн дүн нь өмнөх оноос 2.5 дахин өсөж, 123.4 сая ам.доллар болжээ. Импортлогчдын зүгээс уул уурхайн салбар идэвхжиж эдийн засгийн өсөлт нэмэгдэж байгаа нь импорт өсөхөд голлон нөлөөлж байгаа гэдгийг онцолсон юм. Нийт ачааны автомашины импортын 85 хувийг БНХАУ-аас импортолж байна. Харин суудлын автомашины импортын мөнгөн дүнгийн хэмжээ нь 37 хувиар өсөж, 134.1 сая ам.доллараар хэмжигдэж байна. Шинэ автомашин импортлогчдын хувьд энэ онд шинэ загварын автомашинуудыг оруулж ирж байна.

Тухайлбал, “Моннис моторс” компани Францын “Renault” брэндийн автомашиныг албан ёсоор худалдаалж эхэлжээ. “Тус брэндийн автомашин үнийн хувьд харьцангуй хямд гэдэг утгаараа зах зээлд эрэлттэй байх боломжтой” гэдгийг “Моннис моторс” компаниас мэдээллээ.

Үүнээс гадна “Таванбогд” компани хөдөө, орон нутагт аяллаар явахад илүү тохиромжтой “Land Cruiser-76” загварын автомашиныг шинээр оруулж ирсэн байна. Энэхүү автомашин нь зургаан цилиндрийн хөдөлгүүртэй, 271 морины хүчтэй бөгөөд 105 сая төгрөгөөр борлуулагдаж байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Төв банк: Валютын захад хүчтэй савлагаа үүсгэхгүй байх хэмжээний гадаад валютын нөөцтэй болсон

Монголбанк ээлжит бус валютын дуудлага худалдаа зохион байгуулж зах зээлд 88.7 сая ам.доллар нийлүүлээд байна. 6-р сарын 15-наас хойш банкуудаас гурван удаа 290 орчим сая ам.долларын гадаад валют худалдан авах санал ирүүлсэн ч Монголбанк оролцоогүй байсан юм. Учир нь Төв банк энэ оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлд ханшийг зах зээлийн зарчмаар уян хатан тогтоох бодлого баримталж байна. Харин валютын захад хүчтэй савлагаа үүсгэхгүй байх хэмжээний гадаад валютын нөөцтэй болсныг Монголбанк мэдэгдэж байгаа юм. Гадаад валютын албан нөөц энэ оны дөрөвдүгээр сарын байдлаар 2.98 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 142 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Төгрөгийн ханш энэ оны дөрөвдүгээр сард 2017 оны долоодугаар сараас хойш хамгийн дээд цэгтээ хүрч чангарсан аж. Цаашид гадаад валютын орох урсгал нэмэгдэх төлөвтэй байна. Тухайлбал, Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөрийн хүрээнд энэ онд 836 сая ам.доллар орж ирнэ гэж Монголбанк мэдээлсэн юм. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 100 гаруй сая ам.доллараар өссөн үзүүлэлт болж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.